

ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ШААРДЛАГАТАЙ ДҮРМҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА

ИНЕГ нь Иргэний нисэхийн тухай хууль болон Чикагогийн конвенцийн дагуу ИНД-ийг сайжруулах ажлыг сүүлийн 5 жил хийж, 2019, 2021 онуудад нийт 47 ИНД-ийг шинэчлэн батлуулж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

ИНЕГ-ын Даргын 2015 оны А/791 дугаар тушаалаар нислэгийн аюулгүй байдлын зохицуулалтын дүрмийн бүтцийг хууль болон конвенцийн шаардлагад нийцүүлэн, шаардлагатай эдийн засгийн зохицуулалтын дүрмийг шинээр боловсруулах үүрэг өгч, санхүүжилтийг шийдсэн боловч өдийг хүртэл энэ тушаал бүрэн хэрэгжээгүй байна.

Иргэний нисэхийн тухай хуулиар тогтоосон ИНЕГ-ын үйл ажиллагааны чиглэл, зорилгод нийцдэггүй, дараах хууль болон конвенцийн шаардлага зөрчсөн, ИНЕГ-аас хэрэгжилтэд нь ямар ч хяналт шалгалт, аудит хийдэггүй, мөрдөж хэрэглэдэггүй дүрмүүд ИНД-үүдтэй зөрчилдөн, ИНЕГ-ын дүрмийн бүтцэд байсаар байна. Үүнд:

- Захиргааны ерөнхий хуулийн 60.1.2-т “дүрэм нь тусгайлан эрх олгосон тухайн хуулийн агуулга, зорилго, хүрээнд нийцсэн байх”;
- Чикагогийн конвенцийн Зүйл 37-д нислэгийн аюулгүй байдлын зохицуулалтын дүрэм нь “Олон улсын иргэний нисэхийн байгууллагын стандарт, зөвлөмжийн шаардлагад нийцсэн байх”.
- Иргэний нисэхийн тухай хуулийн 8.4.1 болон 11.1-д “иргэний нисэхийн дүрмийг Чикагогийн конвенцийн Хавсралтын дагуу боловсруулах”;
- “Иргэний нисэхийн тухай хуулийн 11.2-т заасан “Иргэний нисэхийн багц дүрмээр зохицуулах үйл ажиллагаа”-нд багтдаггүй;
- Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогын баримт бичгийн 2.1.2-т “...Чикагогийн конвенцийн Хавсралтуудын стандарт, зөвлөмжийн шаардлагад нийцүүлэн ... Иргэний нисэхийн багц дүрмийг шинэчлэн боловсруулж батлуулах”;
- Иргэний нисэхийн ерөнхий газрын дүрмийн 1.1-д “Иргэний нисэхийн ерөнхий газар нь иргэний нисэхийг хөгжүүлэх талаар төрөөс баримталж байгаа бодлого, хөтөлбөр, иргэний нисэхийн тухай хууль тогтоомж, Олон улсын иргэний нисэхийн байгууллагын стандарт, зөвлөмжийг хэрэгжүүлэх асуудлыг эрхэлсэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг мөн”;
- ИНД-ийн нэр томъёоны тайлбарт “Иргэний нисэхийн дүрэм гэж Конвенцийн Аппех-ын стандарт, зөвлөмжийн суурь түвшнийг хангах зорилгоор Хуульд нийцүүлэн боловсруулж, Сайдын баталсан, иргэний нисэхийн аюулгүй байдлын зохицуулалтын дүрмийг”;
- Annex 19 Appendix 1.2-т “Specific operating regulations (CE-2). States shall promulgate regulations to address, at a minimum, national requirements emanating from the primary aviation legislation, for standardized operational procedures, products, services, equipment and infrastructures in conformity with the Annexes to the Convention on International Civil Aviation.”
- Загвар хуулийн 9-р бүлэгт “эдийн засгийн зохицуулалтын чиг үүргийг иргэний нисэхийн аюулгүй байдлын чиг үүргээс ангид, төрийн хоёр өөр байгууллага гүйцэтгэнэ” гэж тус тус заасан байдаг;

Дээрх хууль болон бусад эрх зүйн баримт бичгүүдэд дурдсан “Олон улсын иргэний нисэхийн байгууллагын стандарт, зөвлөмж” гэж Хэлэлцэн тохиролцогч Улсууд хэрэгжүүлэх үүрэгтэй, Чикагогийн Конвенцийн дагуу ICAO-Зөвлөлөөс гаргасан стандарт болон практик зөвлөмжийг ойлгоно. (Status of Annex Components: “Standards and Recommended Practices adopted by the Council under the provisions of the Convention”)

Дээрх хууль болон конвенци зөрчсөн дүрмүүдийг ИНЕГ-ын дүрмийн бүтцээс хасуулж, ЗТХЯ-ны төрийн зохицуулалтад шилжүүлэх хүсэлтийг сүүлийн 4 жил удаа дараа ЗТХЯ-нд хүргүүлж байсан боловч өнөөг хүртэл шийдээгүй байгаагаас төрөөс иргэний нисэхэд хэрэгжүүлэх тухайн дүрмүүд нь эзэнгүйдэж, хэрэгжүүлэлтэд сөргөөр нөлөөлж байна.

АНУ-ын Холбооны Дүрмийн Код-14 (*Code of Federal Regulation*) нь дараах өөр өөр төрийн байгууллагын хариуцдаг нисэхийн болон сансар огторгуйн үйл ажиллагааны зохицуулалтыг багтаасан байдаг. Үүнд:

- Бүлэг 1 - 1-199 нь FAA / Холбооны нисэхийн удирдах газрын зохицуулалт (*Манайхаар ИНЕГ*);
- Бүлэг 2 - 200-399 нь Department of Transport / Тээврийн яамны зохицуулалт (*Манайхаар ЗТХЯ*);
- Бүлэг 3 - 400-1199 нь сансар огторгуйн арилжааны тээвэр, Холбооны нисэхийн удирдах газар (FAA), Тээврийн яамны зохицуулалт (*Манайхаар ЗТХЯ*);
- Бүлэг 5 - 1200-1299 нь NASA / Үндэсний сансар судлалын төвийн зохицуулалт тус тус багтдаг.

<https://www.ecfr.gov/current/title-14>

Code of Federal Regulation (АНУ-ын Холбооны Дүрмийн Код-14)

▼ Title 14	Aeronautics and Space	Part / Section
▶ Chapter I	Federal Aviation Administration, Department of Transportation	1 – 199
▶ Chapter II	Office of the Secretary, Department of Transportation (Aviation Proceedings)	200 – 399
▶ Chapter III	Commercial Space Transportation, Federal Aviation Administration, Department of Transportation	400 – 1199
▶ Chapter V	National Aeronautics and Space Administration	1200 – 1299
▶ Chapter VI	Air Transportation System Stabilization	1300 – 1399

2000 оны эхээр АНУ-ын Тээврийн яамны төрийн зохицуулалтын Бүлэг 2-ын 200-399 дугаартай дүрмүүдэд үндэслэсэн, хууль болон Чикагогийн конвенциор ИНЕГ-ын чиг үүрэгт багтдаггүй дүрмүүдийг ИНЕГ-т хамаарах ИНД-ийн бүтцэд алдаатайгаар оруулснаар төрийн 2 тусдаа байгууллага хэрэгжүүлэх үүрэгтэй төрийн эдийн засгийн болон нислэгийн аюулгүй байдлын зохицуулалтын шаардлагыг зөрчин, төрөөс иргэний нисэхэд баримтлах бодлогын бие даасан, харилцан хамааралгүй байх зарчмыг алдагдуулсан.

ХЗДХЯ-наас хууль, тогтоомжийг зөрчсөн эрх зүйн актуудыг хүчингүй болгох ажлыг зохион байгуулахыг шаардаж байгаа бөгөөд дээрх хууль, Чикагогийн конвенци болон түүний Хавсралтаар ИНЕГ-т зохицуулах эрх нь олгогдоогүй, тус газрын чиг үүрэг, нислэгийн аюулгүй байдлын зохицуулалтад багтдаггүй дараах дүрмүүдийг хүчингүй болгож, шаардлагатай зохицуулалтыг хуулиар эрх нь олгогдсон төрийн байгууллагад яаралтай шилжүүлэх арга хэмжээ авах шаардлагатай байна. Үүнд:

1. ИНД-131 Агаарын хөлгийн түрээс (*АНУ-ын Тээврийн яамны дүрэм-218*);
2. ИНД-191 Иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон мэдээллийн нууцыг хамгаалах (*АНУ-ын Тээврийн яамны дүрэм*);
3. ИНД-203 Агаарын хөлгийн осол зөрчлийг шинжлэн шалгах (*ЗТХЯ-ны чиг үүрэгт багтдаг бөгөөд тус алба нь бүх заавар, журмаа Сайдаар батлуулсан*);
4. ИНД-303 Агаарын тээвэрлэгчийн даатгал (*АНУ-ын Тээврийн яамны дүрэм-205*);
5. ИНД-307 Захиалгат нислэгийн зөвшөөрөл (*АНУ-ын Тээврийн яамны дүрэм-212*);
6. ИНД-313 Гадаадын агаарын тээвэрлэгчдийн үйлдэх захиалгат нислэг (*АНУ-ын Тээврийн яамны дүрэм-214*);
7. ИНД-321 Статистикийн мэдээлэл (*ИНЕГ ИНД-12-оор зохицуулдаг, АНУ-ын Тээврийн яамны дүрэм-217 Гадаадын агаарын тээвэрлэгчийн статистикийн дүрэм*);
8. ИНД-329 Тээвэрлэлтийн гэрээ (*АНУ-ын Тээврийн яамны дүрэм-253*);
9. ИНД-331 Зорчигчийн бүртгэл (*АНУ-ын Тээврийн яамны дүрэм-243*).

Мөн зөрчил давхардал үүсгэдэг, зөвлөмжийн цуврал, маягтгүй, зөвшөөрөлгүй авсан, зохиомол бөгөөд ИНЕГ-ын Аюулгүй ажиллагааны зөвлөлийн 2017 оны хурлын 01/17 дугаар шийдвэрийг үндэслэн ЗТХЯ-нд хүчингүй болгуулахаар удаа дараа хүргүүлж байсан дараах ИНД-үүдийг яаралтай хүчингүй болгох шаардлагатай байна. Үүнд:

1. ИНД-138 Эрэн хайх, авран туслах үйл ажиллагаа (*нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагаас онцгой байдлын албанд аюул тулгарсан, сураггүй болсон агаарын хөлгийн талаар анхааруулах мэдээ өгөх заалт ИНД-172-т орсон бөгөөд эрэн хайх авран туслах үйл ажиллагааг төрийн бусад мэргэжлийн байгууллагууд гүйцэтгэдэг*);
2. ИНД-144 Нисэхийн хангамжийн байгууллага, гэрчилгээжүүлэлт (*Хууль, Чикагогийн конвенци болон түүний Хавсралтаар Иргэний нисэхийн ерөнхий газарт зохицуулах эрх нь олгогдоогүй, тусдаа газрын тосны салбарын стандартын зохицуулалттай, Монгол Улсаас өөр аль ч улсад байдаггүй зохиомол дүрэм*);
3. ИНД-183 Иргэний нисэхийн итгэмжлэгдсэн шалгагч (*ИНД-61-ээр зохицуулдаг боловч АНУ-ын FAR-183-ыг давхардуулан авсан нь Монголын иргэний нисэхэд өмнө байсан багш болон шалгагч-нисгэгчийн тогтсон систем алдагдах шалтгаан болсон*);
4. ИНД-301 Ачааны агаарын тээвэрлэгчид эрх олгох (*ИНД-119-ээр зохицуулдаг, зохиомол дүрэм*).

ИНЕГ-ын үндсэн чиг үүрэг болох нислэгийн аюулгүй байдлын зохицуулалтад багтдаггүй, Захиргааны ерөнхий хууль, Иргэний нисэхийн тухай хууль, Чикагогийн конвенци болон ИНЕГ-ын дүрэм зөрчсөн дээрх дүрмүүдийг хуулийн дагуу холбогдох төрийн байгууллагад яаралтай шилжүүлэхгүй бол болзошгүй осол, сүйрлийн дараа хууль, эрх зүйн ноцтой асуудалд орж болох бодит аюул тулгарч байна.

Хуулийн хариуцлага:

ИНЕГ-ын чиг үүрэгт, нислэгийн аюулгүй байдлын зохицуулалтад багтдаггүй, Захиргааны ерөнхий хууль, Иргэний нисэхийн тухай хууль болон Чикагогийн конвенци зөрчиж, ИНЕГ-ын ИНД-ийн бүтцэд орж батлагдсан дээрх дүрмүүдийг ИНЕГ-аас хэрэгжүүлэх зорилгоор хяналт, шалгалт, аудит огт хийхгүй байгаа нь дараах хуулиудын дагуу хариуцлага хүлээлгэх үндэслэл болох бодит нөхцөл байдал үүссэн байна. Үүнд:

- **Зөрчлийн тухай хуулийн 14.8 дугаар зүйл. Иргэний нисэхийн тухай хууль зөрчих** “14.8.2. Хуулиар эрх олгогдсон этгээд нислэгийн аюулгүй байдлын, эсхүл аюулгүй ажиллагааны үзлэг, шалгалтыг зохих журмын дагуу хийгээгүй бол үзлэг, шалгалт хийх эрхийг нэг жил хүртэл хугацаагаар хасаж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”
- **Захиргааны ерөнхий хуулийн 105 дугаар зүйл. Хууль зөрчсөн албан тушаалтанд хүлээлгэх хариуцлага** “105.2. Тухайн албан тушаалтныг томилсон болон дээд шатны байгууллагын албан тушаалтан энэ хуулийн 105.1-д заасан зөрчил гаргасан, эсхүл **захиргааны шийдвэрийг сайн дураараа эс биелүүлсэн** албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дараах шийтгэлийн аль нэгийг оногдуулна:
 - 105.2.1. хууль биелүүлж ажиллахыг хаалттай болон нээлттэй сануулах;
 - 105.2.2. албан тушаалын цалингийн хэмжээг зургаан сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;
 - 105.2.3. ажлаас халах;
 - 105.2.4. нийтийн албанд нэгээс арав хүртэл жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах.”
- **Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйл. Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах** “48.1. Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 37, 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн, албан үүргээ биелүүлээгүй болон энэ хуульд заасан бусад тохиолдолд тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан төрийн үйлчилгээний албан хаагчаас бусад албан хаагчид дараах сахилгын шийтгэлийн аль тохирохыг ногдуулна:
 - 48.1.1. өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах;
 - 48.1.2. нийт ажилтанд зарлах хэлбэрээр нээлттэй сануулах;
 - 48.1.3. албан тушаалын цалингийн хэмжээг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;
 - 48.1.4. төрийн албанаас халах;

48.1.5. төрийн албанд гурван жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах;

48.1.6. хуульд заасан бусад.

Тайлбар: 37.1.13. албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах”

- Эрүүгийн хууль 22.1 дүгээр зүйл. Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах “1. Нийтийн албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, эсхүл зориуд хэрэгжүүлэхгүй байж өөртөө, бусдад давуу байдал бий болгосон бол нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: - Энэ хуульд заасан “урвуулан ашиглах” гэж албан үүрэг, албан тушаал, албан тушаалын байдлын эрх мэдлээ албаны эрх ашгийн эсрэг, эсхүл хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийх, эрх мэдлээ хэтрүүлэхийг ойлгоно.”